НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Эко хотын тээвэр ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/048/НА-СТА-ОНӨҮГ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал<br>Утас: 70007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn<br><br>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр<br>Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Я.Алтанцэцэг<br>Утас: 315093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Д.Мөнхдэлгэр<br>Утас: 325093 Цахим хаяг: munkhdelgerd@audit.gov.mn<br><br>Аудитор: Д.Эрдэнэбулган<br>Утас: 325093 Цахим хаяг:erdenebulgand@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.05.13 № 667
танай ______________-ны № ______________-т

ЭКО ХОТЫН ТЭЭВЭР
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ц.ЧИНЗОРИГТ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эко хотын тээвэр ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар "Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл" хэсэгт тайлбарласан зүйлсийн нөлөөг эс тооцвол, тус байгууллагын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 342.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1261 дугаар захирамжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 148.4 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл хүлээн авч, нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.

Байгууллага нь тайлант онд 9,834.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 9,803.9 сая төгрөгийн зардал гарган 30.0 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Орон нутгийн төсөвт хог хаягдлын үйлчилгээний хураамжаас 1,540.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оноос 47.4 хувиар өссөн байна.

1426050716

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Захирлын 2025 оны А/16 дугаар тушаалаар шинэчлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн боловсруулсан боловч тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн нь бодлогын баримт бичигтэй нийцэхгүй байна.

Байгууллагын Төлөөлөн удирдах зөвлөл сар бүр эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 100 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Хан-Уул дүүргийн 6 хороодын зам талбайн цэвэрлэгээ, хог тээвэрлэлт, тохижилтын ажлыг хариуцан ажиллаж, 301 аж ахуйн нэгж, 63 иргэн, 23 сууц өмчлөгчдийн холбоотой гэрээ байгуулсан байна. Тайлант онд 609 төвлөрсөн хогийн цэгээс 46,115.6 тонн хог хаягдлыг тээвэрлэн, 3,490,342.0 м.кв зам, талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хийж гүйцэтгэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\yavsan bichig\Dughelt 2026.docx

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\wordlywsan bichig\Dugnelt 2026.docx

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

***/төгрөгөөр/***

| Код | Үзүүлэлт | Тод руулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **4** | **735,032,457.96** | **875,498,576.01** |
| 31100 | Кассанд байгаа бэлэн мөнгө | | | 390,149.57 |
| 31110 | Төгрөг | | | 390,149.57 |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | | 735,032,457.96 | 875,108,426.44 |
| 31210 | Төгрөг | | 735,032,457.96 | 875,108,426.44 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | | 735,032,457.96 | 875,108,426.44 |
| 312131 | ХХБанк | | 733,559,241.78 | 869,153,697.87 |
| 312132 | ХААН Банк | | 1,066,386.18 | 5,899,228.57 |
| 312133 | Хаан ЖМС 5622916634 | | 406,830.00 | 55,500.00 |
| **32** | **БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | | | |
| **33** | **АВЛАГА** | **5** | **17,284,808.00** | **174,306,030.61** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | | 777,308.00 | 8,837,079.86 |
| 33101 | Цалингийн авлага | | | 8,837,079.86 |
| 33102 | НДШ-ийн авлага | | 4,108.36 | |
| 33103 | ХАОАТ-ын авлага | | 773,199.64 | |
| 33401 | Дансны авлага (ТӨҮГ) | | | 148,509,042.00 |
| 33402 | Татвар НДШ-н авлага (ТӨҮГ) | | | 8,264,818.75 |
| 33500 | Бусад авлага | | 16,507,500.00 | 8,695,090.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | | 6,407,500.00 | 6,745,090.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | | 10,100,000.00 | 1,950,000.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | | | |
| 34700 | Бусад урьдчилгаа | | | |
| 34710 | Урьдчилгаа тооцоо | | | |
| 34711 | Бараа материал бэлтгэх урьдчилгаа | | | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **6** | **29,319,682.00** | **60,428,300.00** |
| 35100 | Түүхий эд материал | | | 44,747,620.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | | | 44,747,620.00 |
| 35400 | Хангамжийн материал | | 29,319,682.00 | 15,680,680.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 610,500.00 | |
| 35420 | Аж ахуйн материал | | 4,049,000.00 | 2,907,000.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | | 2,623,500.00 | 9,481,880.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | | 14,168,282.00 | 3,291,800.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | | 7,868,400.00 | |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | | **204,643,000.20** | **77,245,059.00** |
| 36600 | Бусад нөөц | | 194,737,900.20 | |
| 36800 | Бусад эргэлтийн хөрөнгө (ТӨҮГ) | | 9,905,100.00 | 77,245,059.00 |
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)** | | **986,279,948.16** | **1,187,477,965.62** |
| **37** | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | | | |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **7** | **3,164,475,397.75** | **2,781,069,575.57** |
| 39200 | Биет хөрөнгө | | 3,162,366,897.75 | 2,779,226,575.57 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 16,940,330.00 | 26,440,330.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл - Барилга | | (462,466.59) | (1,705,316.41) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | | 3,780,408,566.78 | 3,933,808,566.78 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл | | (1,004,172,080.27) | (1,510,797,734.42) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | | 388,539,860.00 | 431,256,560.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж | | (59,601,530.66) | (141,328,819.41) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 48,283,500.00 | 54,335,470.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл - Тавилга | | (7,569,281.51) | (12,782,480.97) |
| 39300 | Биет бус хөрөнгө | | 2,108,500.00 | 1,843,000.00 |
| 39301 | Програм хангамж | | 2,655,000.00 | 2,655,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж | | (546,500.00) | (812,000.00) |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)** | | **3,164,475,397.75** | **2,781,069,575.57** |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)** | | **4,150,755,345.91** | **3,968,547,541.19** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **9** | **1,355,199,324.91** | **1,142,943,105.92** |
| 41300 | Өглөг | | 60,191,455.38 | 403,182.31 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | | | 403,182.31 |
| 41311 | Цалингийн өглөг | | | |
| 41312 | НДШ-ийн өглөг | | | 403,182.31 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | | |
| 413201 | Бичиг хэргийн өглөг | | | |
| 413205 | Тээвэр, шатахууны өглөг | | | |
| 413213 | Бусад зардлын өглөг | | | |
| 41360 | Бусад өглөг | | 60,191,455.38 | |
| 41363 | Татварын өр - ТӨҮГ | | 60,191,455.38 | |
| 41400 | Урьдчилж орсон орлого | | 1,295,007,869.53 | 1,142,539,923.61 |
| 41440 | Бусад урьдчилж орсон орлого | | 1,295,007,869.53 | 1,142,539,923.61 |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **10** | | |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)** | | **1,355,199,324.91** | **1,142,943,105.92** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | **2,795,556,021.00** | **2,825,604,435.27** |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | | 2,795,556,021.00 | 2,825,604,435.27 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 2,013,257,538.37 | 2,795,556,021.00 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 782,298,482.63 | 30,048,414.27 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)** | | **2,795,556,021.00** | **2,825,604,435.27** |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)** | | **4,150,755,345.91** | **3,968,547,541.19** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

***/төгрөгөөр/***

| Код | Үзүүлэлт | Тод руулга | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|---|
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | | | |
| **13** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **6,726,338,622.40** | |
| 1330 | Төсвийн захирагчдаас | | 6,726,338,622.40 | |
| 133004 | Дээд шатны төсвийн эрх захирагчаас олгосон санхүүжилт | | 6,726,338,622.40 | |
| **12** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | | **365,823,087.10** | **9,833,981,166.38** |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | | 365,823,087.10 | 9,833,981,166.38 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 126,601,518.00 | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | | 126,601,518.00 | |
| 120010 | Борлуулалтын орлого (цэвэр) - ТӨҮГ | | 3,038,249.65 | 9,476,465,321.19 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 102,888,729.25 | 261,294,612.64 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал | | 133,294,590.20 | 96,221,232.55 |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2** | **7,092,161,709.50** | **9,833,981,166.38** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **6,307,663,226.87** | **9,803,932,752.11** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 6,292,557,399.82 | 9,738,536,424.80 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | | 3,282,645,026.01 | 5,565,728,553.34 |
| 210101 | Үндсэн цалин | | 3,275,666,026.01 | 5,565,728,553.34 |
| 210104 | Урамшуулал | | 6,979,000.00 | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 421,295,437.79 | 716,982,233.86 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн - ТӨҮГ | | 421,295,437.79 | 716,982,233.86 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 184,860,806.00 | 264,893,299.00 |
| 210304 | Байрны түрээс | | 184,860,806.00 | 263,050,000.00 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн - ТӨҮГ | | | 1,843,299.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 1,242,585,183.66 | 1,631,853,169.08 |
| 210401 | Бичиг хэрэг | | 7,678,939.00 | 9,186,631.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 1,090,571,348.00 | 1,235,840,459.38 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 1,431,268.66 | 3,182,223.50 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 109,291,000.00 | 281,031,380.20 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 33,612,628.00 | 102,612,475.00 |
| 2105 | Нормативт зардал | | | 354,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | | 354,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 358,999,215.00 | 321,027,770.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 154,821,463.00 | 200,170,551.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 204,177,752.00 | 116,916,419.00 |
| 210604 | Урсгал засвар | | | 3,940,800.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 26,920,680.00 | 4,319,884.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | 9,416,980.00 | 4,319,884.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | 17,503,700.00 | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 119,871,951.43 | 154,471,758.52 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 30,359,378.00 | 35,306,157.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 4,500,000.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 427,467.00 | 7,037,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | | 264,000.00 | 698,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 14,869,946.80 | 16,237,072.43 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | 649,874.95 | 1,556,755.77 |
| 210813 | Бусад зардал - ТӨҮГ | | 1,492,060.00 | 77,273,120.00 |
| 210814 | Орлогын татварын зардал - ТӨҮГ | | 61,450,981.68 | 6,280,003.32 |
| 210816 | Татварын байгууллагад төлсөн - ТӨҮГ | | 359,238.00 | |
| 210817 | Даатгалын төлбөрт төлсөн - ТӨҮГ | | 5,499,005.00 | 10,083,150.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 655,379,099.93 | 1,078,905,257.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 227,837,928.00 | 523,404,098.10 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол | | 427,541,171.93 | 555,501,158.90 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 15,105,827.05 | 65,396,327.31 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 15,105,827.05 | 65,396,327.31 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 11,705,827.05 | 24,605,115.12 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 3,400,000.00 | 40,791,212.19 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **2,200,000.00** | |
| 223 | БУСАД ХӨРӨНГӨ | | 2,200,000.00 | |
| 223001 | Бусад хөрөнгө | | 2,200,000.00 | |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **3** | **6,309,863,226.87** | **9,803,932,752.11** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | | **782,298,482.63** | **30,048,414.27** |
| **14** | **ҮЙЛ АЖИЛАГААНЫ БУС ОРЛОГО** | | | |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)** | | | |
| **23** | **Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл** | | | |
| **24** | **Гадаад зээлийн үндсэн төлбөр** | | | |
| **25** | **Гадаад валютын ханшийн зөрүү** | | | |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | | | |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)** | | **782,298,482.63** | **30,048,414.27** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

***/төгрөгөөр/***

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | | |
| **13** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **6,726,338,622.40** | |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 6,726,338,622.40 | |
| 133004 | Дээд шатны төсвийн эрх захирагчаас олгосон санхүүжилт | 6,726,338,622.40 | |
| **12** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | **129,639,767.65** | **9,476,465,321.19** |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | 129,639,767.65 | 9,476,465,321.19 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 126,601,518.00 | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | 126,601,518.00 | |
| 120010 | Борлуулалтын орлого (цэвэр) - ТӨҮГ | 3,038,249.65 | 9,414,670,763.53 |
| 120013 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого - ТӨҮГ | | 61,794,557.66 |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **6,855,978,390.05** | **9,476,465,321.19** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,936,300,161.05** | **9,124,221,491.14** |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 5,919,683,057.45 | 9,090,522,776.95 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 2,689,175,144.22 | 4,778,974,550.42 |
| 210101 | Үндсэн цалин | 2,460,142,852.22 | 4,198,649,045.75 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | | 540,595,000.00 |
| 210104 | Урамшуулал | 6,979,000.00 | 39,730,504.67 |
| 210105 | Гэрээт ажлын цалин | 39,000,000.00 | |
| 210106 | Ажилчдад төлсөн - ТӨҮГ | 183,053,292.00 | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 774,518,766.04 | 1,316,849,312.10 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн - ТӨҮГ | 774,518,766.04 | 1,316,849,312.10 |

| | | | |
|---|---|---|---|
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 186,483,306.00 | 264,800,799.00 |
| 210304 | Байрны түрээс | 186,483,306.00 | 262,957,500.00 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн - ТӨҮГ | | 1,843,299.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 901,878,011.14 | 1,303,075,443.33 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,800,400.00 | 8,414,435.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 615,362,195.00 | 1,200,040,834.83 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,855,170.14 | 3,182,223.50 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 165,790,054.00 | 52,382,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 57,355,961.00 | 39,055,450.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 24,933,731.00 | |
| 210410 | Бараа материал худалдан авахад төлсөн - ТӨҮГ | 27,780,500.00 | |
| 2105 | Нормативт зардал | | 354,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 354,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 333,668,931.00 | 468,909,150.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 140,110,857.00 | 255,617,232.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 181,163,624.00 | 210,557,418.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,394,450.00 | 2,734,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 9,416,980.00 | 4,319,884.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 9,416,980.00 | 4,319,884.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 870,671,019.05 | 448,421,380.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 568,889,941.32 | 35,713,157.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 4,500,000.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 427,467.00 | 6,156,600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 1,430,900.00 | 394,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,112,618.00 | 16,237,072.43 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 649,874.95 | 1,551,755.77 |
| 210813 | Бусад зардал - ТӨҮГ | | 78,082,690.00 |
| 210814 | Орлогын татварын зардал - ТӨҮГ | | 11,000,000.00 |
| 210816 | Татварын байгууллагад төлсөн - ТӨҮГ | 280,161,212.78 | 289,467,404.80 |
| 210817 | Даатгалын төлбөрт төлсөн - ТӨҮГ | 5,499,005.00 | 9,818,700.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 153,870,900.00 | 504,817,758.10 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 153,870,900.00 | 504,817,758.10 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 16,617,103.60 | 33,698,714.19 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 16,617,103.60 | 33,698,714.19 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 7,532,836.93 | |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 300,845.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,084,266.67 | 33,397,869.19 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)** | **5,936,300,161.05** | **9,124,221,491.14** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)** | **919,678,229.00** | **352,243,830.05** |
| **14** | **ҮЙЛ АЖИЛАГААНЫ БУС ОРЛОГО** | | |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)** | | |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **185,753,000.00** | **211,777,712.00** |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 185,753,000.00 | 211,777,712.00 |
| 2251 | Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн | 185,753,000.00 | 211,777,712.00 |
| 225101 | Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн - ТӨҮГ | 185,753,000.00 | 63,268,670.00 |
| 225102 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/ | | 148,509,042.00 |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **185,753,000.00** | **211,777,712.00** |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)** | **(185,753,000.00)** | **(211,777,712.00)** |

| | | | |
|---|---|---|---|
| 9 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | | |
| 23 | **Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл** | | |
| 24 | **Гадаад зээлийн үндсэн төлбөр** | | |
| 25 | **Гадаад валютын ханшийн зөрүү** | | |
| 10 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | | |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)** | | |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)** | **733,925,229.00** | **140,466,118.05** |
| 14 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **1,107,228.96** | **735,032,457.96** |
| 15 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **735,032,457.96** | **875,498,576.01** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

***/төгрөгөөр/***

| Код | Үзүүлэлт | Засгийн хөрөнгө оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | **2,013,257,538.37** | **2,013,257,538.37** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | 2,013,257,538.37 | 2,013,257,538.37 |
| 7 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | |
| 8 | Зарласан ноогдол ашиг | | | | |
| 9 | Тайлант үеийн үр дүн | | | 782,298,482.63 | 782,298,482.63 |
| 10 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | | | **2,795,556,021.00** | **2,795,556,021.00** |
| **11** | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | | | **2,795,556,021.00** | **2,795,556,021.00** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | 2,795,556,021.00 | 2,795,556,021.00 |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | |
| 18 | Зарласан ноогдол ашиг | | | | |
| **19** | **Тайлант үеийн үр дүн** | | | **30,048,414.27** | **30,048,414.27** |
| **20** | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | **2,825,604,435.27** | **2,825,604,435.27** |

## 2.6 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

***/төгрөгөөр/***

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Төрөөс олгох үйл ажиллагааны дэмжлэг | - | - | - | - |
| Дээд шатны төсвийн эрх захирагчаас олгосон санхүүжилт | - | - | - | - |
| Туслах үйл ажиллагааны орлого | - | - | - | - |
| Борлуулалтын орлого -ТӨҮГ | 8,902,583,382.00 | 9,476,465,321.19 | (573,881,939.19) | 106.4 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө | - | 61,294,612.64 | (261,294,612.64) | - |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Материал | - | 6,221,232.55 | (96,221,232.55) | - |
| Бусад орлого | - | - | - | - |
| Цахилгааны төлбөрийн орлого | - | - | - | - |
| **Нийт үйл ажиллагааны орлого** | 8,902,583,382.00 | 9,833,981,166.38 | (931,397,784.38) | 110.5 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 6,009,450,400.00 | 5,565,728,553.34 | 443,721,846.66 | 92.6 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 781,235,262.00 | 716,982,233.86 | 64,253,028.14 | 91.8 |
| Байрны түрээс | 346,980,000.00 | 262,720,000.00 | 84,260,000.00 | 75.7 |
| Гэрэл, цахилгаан | - | 1,843,299.00 | (1,843,299.00) | - |
| Цэвэр, бохир ус | - | - | - | - |
| Бичиг хэрэг | 9,186,631.00 | 9,186,631.00 | - | 100.0 |
| Тээвэр, шатахуун | 1,156,000,000.00 | 1,235,840,459.38 | (79,840,459.38) | 106.9 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,980,000.00 | 3,182,223.50 | 1,797,776.50 | 63.9 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 80,533,330.00 | 281,031,380.20 | (200,498,050.20) | 349.0 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 41,213,369.00 | 102,612,475.00 | (61,399,106.00) | 249.0 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 354,500.00 | 354,500.00 | - | 100.0 |
| Тавилга | - | - | - | - |
| Багаж, техник, хэрэгсэл | 189,600,000.00 | 200,170,551.00 | (10,570,551.00) | 105.6 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 188,601,038.00 | 116,916,419.00 | 71,684,619.00 | 62.0 |
| Урсгал засвар | 3,940,800.00 | 3,940,800.00 | - | 100.0 |
| Томилолт | 4,319,884.00 | 4,319,884.00 | - | 100.0 |
| Зочин төлөөлөгч хүлээн авах | - | - | - | - |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 24,000,000.00 | 35,306,157.00 | (11,306,157.00) | 147.1 |
| Аудит, баталгаажуулах, зэрэглэл тогтоох | - | - | - | - |
| Даатгалын үйлчилгээ | 10,083,150.00 | 10,083,150.00 | - | 100.0 |
| Тээврийн хэрэгслийн татвар | - | 7,037,300.00 | (7,037,300.00) | - |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 698,200.00 | 698,200.00 | - | 100.0 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 16,237,072.43 | (16,237,072.43) | - |
| Газрын төлбөр | - | - | - | - |
| Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 1,357,966.00 | 1,556,755.77 | (198,789.77) | 114.6 |
| Бусад зардал - ТӨҮГ | 2,048,852.00 | 77,273,120.00 | (75,224,268.00) | 3,771.5 |
| Орлогын татварын зардал - ТӨҮГ | - | 6,280,003.32 | (6,280,003.32) | - |
| Татварын байгууллагад төлсөн - ТӨҮГ | - | - | - | - |
| Бараа үйлчилгээний бусад зардал | - | 523,734,098.10 | (523,734,098.10) | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | - | - | - | - |
| Элэгдэл | - | 555,501,158.90 | (555,501,158.90) | - |
| Бусад урсгал шилжүүлэг | 48,000,000.00 | 65,396,327.31 | (17,396,327.31) | 136.2 |
| Бусад хөрөнгө | - | - | - | - |
| **Нийт үйл ажиллагааны зардал** | 8,902,583,382.00 | 9,803,932,752.11 | (901,349,370.11) | 110.1 |
| **Үйл ажиллагааны алдагдал** | - | - | - | - |
| Үйл ажиллагааны бус орлого | - | - | - | - |
| **Нийт орлого** | 8,902,583,382.00 | 9,833,981,166.38 | (931,397,784.38) | 110.5 |
| **Нийт зардал** | 8,902,583,382.00 | 9,803,932,752.11 | (901,349,370.11) | 110.1 |
| Авлага | | 174,306,030.61 | (174,306,030.61) | - |
| Нийт өр төлбөр | | 1,142,943,105.92 | (1,142,943,105.92) | - |
| Орон тоо | 144 | 136 | 8 | 94.4 |

## 3. ОНӨААТҮГ, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Эко хотын тээвэр” ОНӨААТҮГ нь Хан-Уул дүүргийн ИТХ-ын 2021 оны 40 дүгээр тогтоолоор дүүргийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ, тохижилтын үйлчилгээ үзүүлэх, ногоон байгууламжийг байгуулах, арчлах, хамгаалах чиг үүрэгтэйгээр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.Тус байгууллагын эрхэм зорилго нь “Эрүүл, цэвэр эко орчныг бүрдүүлэхийн төлөө стандарт, шаардлагад нийцсэн хог тээвэрлэлт, зам талбайн цэвэрлэгээ, тохижилтын үйлчилгээг тасралтгүй, шуурхай гүйцэтгэхэд оршино” гэж тодорхойлжээ. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах;
- Шинэ техник, технологийг нэвтрүүлэх;
- Үйл ажиллагаанд мөрдөгдөх стандартыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;
- Олон нийтэд эерэг нөлөөлөл бүхий үйл ажиллагааг сурталчлах.

Тайлант онд Хан-Уул дүүргийн 1, 2, 3, 19, 20, 23 дугаар хороодын зам талбайн цэвэрлэгээ, хог тээвэрлэлт, тохижилтын ажлыг гүйцэтгэж, 301 аж ахуйн нэгж, 63 иргэн, 23 сууц өмчлөгчдийн холбоотой гэрээ байгуулан ажилласан. Нийт 609 төвлөрсөн хогийн цэгээс 46,115.6 тонн хог хаягдлыг тээвэрлэн, 3,490,342.0 метр квадрат зам, талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хийж, орон нутгийн төсөвт хог хаягдлын үйлчилгээний хураамжаас 1,540,843.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оноос 47.4 хувиар өссөн байна.

## 4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 522,657.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

## 5. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өмнөх аудитын зөрчил давтагдаж байгаа тул нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, санхүүгийн тайлангийн стандартын мөрдөлт, холбогдох программ хангамжийн нийцлийг дараагийн аудитад онцлон анхаарч шалгах.

## 6. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 61,552.8 мянган төгрөгийн алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 342,966.5 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 1,584.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 341,382.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 342,966.5 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 94,647.9 мянган төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 7. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Үүнээс Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг санхүүгийн тайлангийн тодруулга хэсэгт дутуу тусгасан байна. | 1 | 16,805.6 | | | 1 | 16,805.6 | 1 | 16,805.6 | | | | |
| Зарим бараа материалыг зохих ангиллаас зөрүүтэй бүртгэсэн байна. | 1 | 44,747.2 | | | 1 | 44,747.2 | 1 | 44,747.2 | | | | |
| Дүн | 2 | **61,552.8** | | | 2 | **61,552.8** | 2 | **61,552.8** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Ажлаас чөлөөлөгдсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад бүрэн эрх дуусгавар болсон байхад цалин олгосон байна. | 1 | 1,584.0 | 1 | 1,584.0 | | | | | | | | |
| Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй ажил гүйлгээг бүртгэн, гүйцэтгэлийн үр дүнг тооцоогүй байна. | 1 | 206,369.0 | | | 1 | 206,369.0 | | | | | | |
| Төсвийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байна. | 1 | 135,013.5 | | | 1 | 135,013.5 | | | | | | |
| Шатахууны бодит зарцуулалтыг батлагдсан нормтой харьцуулан тооцох, хэтрэлтийг илрүүлэх хяналтын тогтолцоо хангалтгүй, авто тээврийн хэрэгслийн техникийн ашиглалтын хувийн хэргийн хөтлөлт хангалтгүй, бүрдүүлэлт дутуу байна. | 1 | | | | | | 1 | | | | | |
| **Дүн** | **4** | **342,966.5** | **1** | **1,584.0** | **2** | **341,382.5** | **1** | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын батлагдсан орон тоонд гарсан өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 342,771.7 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээ, 179,886.2 мянган төгрөгийн зарлагын 5 гүйлгээг мэдээлээгүй, 212 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. | 1 | 522,657.9 | | | 1 | 522,657.9 | | | | | | |
| **Дүн** | **1** | **522,657.91** | | | **1** | **522,657.9** | | | | | | |